



## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 30 өдөр


Дугаар 66

Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

- “Ногоон худалдан авах ажиллагааны техникийн тодорхойлолт боловсруулах аргачлал”-ыг хавсралтаар баталсугай.
- Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Ж.Ганбат/, Хууль, эрх зүйн газар /З.Энхболд/-т тус тус үүрэг болгосугай.



9763000348

Сангийн сайдын 2023 оны  
03 дугаар сарын 20. одрийн  
66. дугаар тушаалын  
хавсралт



## НОГООН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛАХ АРГАЧЛАЛ

1. Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тендерийн жишиг баримт бичгийн дагуу техникийн тодорхойлолт боловсруулахад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 5 дугаар зүйлийн 5.1.28 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн худалдан авах барааны тавигдах шалгуур үзүүлэлтийг эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх чиглэлээр шалгуур үзүүлэлтийг тухайн бараа, ажил, үйлчилгээний онцлогт нийцүүлэн тусгана.

2. Бараа худалдан авах тендер шалгаруулалтын техникийн тодорхойлолтод тусгасан эсэхээс үл хамааран хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтад зааснаар “хог хаягдал дахин боловсруулсан бараа нийлүүлэх тендер ирүүлсэн этгээд”-д давуу эрх олгохыг тендерийн баримт бичигт тусгана.

3. Техникийн тодорхойлолтыг ногоон худалдан авах ажиллагааны зорилтод нийцүүлэх нь хэрэгжих боломжтой, урт хугацаанд эдийн засгийн үр өгөөжтэй байх байдалд үндэслэх ба Монгол Улсын болон тухайн орон нутгийн зах зээлд байхгүй, нийлүүлэх боломжгүй шалгуур үзүүлэлтийг тусгахгүй байх зарчим баримтална.

4. Хуулийн дагуу нийтлэг худалдан авдаг 11 төрлийн бараа, үүний дотор принтерийн хор, цаас, ажлын хувцас, ажлын гутал, саван, ширээ, сандал, компьютер/дэлгэц, принтер/хувилагч, сканер, хөнгөн бетон блок зэргийг худалдан авахад энэ аргачлалын хавсралт дахь жишиг техникийн тодорхойлолтын нөхцөлийг тусгах нь ногоон худалдан авах ажиллагааны зорилтод нийцэхийг анхаарна уу.

5. Жишиг техникийн тодорхойлолт нь эрх зүйн хэм хэмжээ тогтоохгүй бөгөөд захиалагч тендерийн баримт бичгийг боловсруулахад хэрэгцээ, шаардлагадаа нийцүүлэн өөрчлөх эрхтэй.

6. Бараа худалдан авах тендер шалгаруулалтын тендерийн баримт бичигт тухайн барааны хувьд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, Монгол Улсад нийлүүлэгддэг эко шошго бүхий тэмдэглэгээ, эсхүл ногоон бүтээгдэхүүний гэрчилгээ шаардсан бол тендерт оролцогч тендертээ тухайн тэмдэглэгээ, гэрчилгээг ирүүлэх, эсхүл бараа нь түүнтэй дүйцэх болохыг бусад хэлбэрээр нотолж болно.

7. Бараа нийлүүлэх тендер шалгаруулалт техникийн тодорхойлолт болон ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд ашиглах барааны техникийн тодорхойлолтод тухайн бараа материалын онцлогт тохируулан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн шатнаас хог хаягдал болох хүртэл үе шатанд байгаль орчинд нөлөөлөх байдлыг тодорхойлж болно.

8. Захиалагч хэрэглээний хог хаягдлыг дахин боловсруулах боломжтой барааг өөрөө ангилж, дахин боловсруулахад бэлтгэх, хүргүүлэх арга хэмжээ авна. Тухайн захиалагчийн байршил, хог хаягдлын хэмжээнээс шалтгаалан захиалагч тендерт оролцогчийг нийлүүлсэн барааны хэрэглээний хог хаягдлыг дахин боловсруулахаар эргүүлэн авах нөхцөлийг тусгаж болно.

9. Захиалагч ногоон худалдан авах ажиллагаанд холбогдох хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон бол аль нэгийг хангаснаар шаардлагад нийцсэн гэж тооцохоор техникийн тодорхойлолтод тусгаж болно.

10. Захиалагч бараа, ажил, үйлчилгээний техникийн тодорхойлолтын ногоон шалгуур үзүүлэлтэд нийцэх эсэхийг тогтоох шалгалт, туршилтыг эрх бүхий бие даасан этгээдээр хийлгэсэн нотлох баримт, эсхүл энэ тухай холбогдох мэдээлэл ирүүлэхийг шаардаж болно.

11. Захиалагч шаардлагатай гэж үзвэл энэ аргачлалын 10-т заасан шалгалт, туршилтыг өөрөө зохион байгуулж болно.

“Ногоон  
ажиллагааны  
тодорхойлолт  
аргачлал”-ын хавсралт  
худалдан авах  
техникийн  
боловсруулах

## ЖИШИГ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### 1. Принтерийн хор

#### Хамрах хүрээ

Захиалагчид шаардлагатай бүх төрлийн принтерийн хар хоронд тавигдах ногоон шалгуур үзүүлэлтийг тодорхойлох.

#### Байгаль орчны нөлөөлөл

Эрүүл мэндийн нөлөөлөл, хор ялгаруулалт, сав баглаа боодол хог хаягдал үүсгэх, ашиглалтын үеийн эрчим хүчинь зарцуулалт, химиин хүнд элементийн агууламж, эдийн засгийн үр ашиг, байгалийн нөөцийн зарцуулалт зэрэг нь байгаль орчинд их бага хэмжээгээр нөлөөлөх боломжтой юм.

#### Эко шошго

Олон улсад хэрэглэгддэг болон дотоодод хэрэглэгдэх ногоон бүтээгдэхүүний гэрчилгээ, эко шошготой, чанар стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнийг худалдан авах нь ногоон худалдан авалтад тооцогдоно.

#### Ногоон шалгуур үзүүлэлт

##### Үндсэн шалгуур

- Савлагааг дахин цэнэглэх боломжтой байх;
- Буцааж авах нөхцөлтэй байх;
- 100 хувь дахин боловсруулсан, дахин боловсруулах боломжтой сав баглаа боодолтой байх.

##### Нэмэлт шалгуур

- Хэвлэлтийн тоо ширхэг өндөр байх

#### Ногоон шалгуур үзүүлэлтийг баталгаажуулах

Бүтээгдэхүүн нийлүүлэгч нь захиалагчийн санал болгож буй шалгуур үзүүлэлтийг хангаж байгааг нотлох баримт захиалагчид ирүүлэх шаардлагатай, ижил төрлийн бараа бүтээгдэхүүнтэй харьцуулсан үзүүлэлт, үйлдвэрлэгчийн техникийн тодорхойлолт зэрэг баримт бичгийг үндэслэн тодорхойлно.

№	Шалгуур үзүүлэлт	Баталгаажуулалт
---	------------------	-----------------

Үндсэн шалгуур		
1	Савлагааг дахин цэнэглэх боломжтой байх	Үйлдвэрлэгчийн тодорхойлолт
2.	Буцааж авах нөхцөлтэй байх	Нийлүүлэгчээс буцааж авах нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгах
3.	100 хувь дахин боловсруулсан, дахин боловсруулах боломжтой сав баглаа боодлой байх	Тэмдэг, тэмдэглэгээтэй байх
Нэмэлт шалгуур		
4.	Хэвлэлтийн тоо ширхэг өндөр байх	Ижил төрлийн харьцуулах, тодорхойлолт бүтээгдэхүүнтэй үйлдвэрлэгчийн

### Техникийн шалгуур үзүүлэлт болон стандарт

Захиалагч худалдан авах барааны техникийн шалгуур үзүүлэлт буюу бүтээгдэхүүний хэлбэр, хэмжээ, төрөл, жин зэрэг бараа бүтээгдэхүүнд шаардлагатай техникийн шалгуур үзүүлэлт болон стандартын шаардлагыг нэмэлтээр тусгаж болно.

### **2. Цаас**

#### Хамрах хурээ

Захиалагчид шаардлагатай бүх төрлийн /бичгийн цаас, ариун цэврийн цаас, салфетик гэх мэт/ цаасыг худалдан авахад тавигдах ногоон шалгуур үзүүлэлтийг тодорхойлох.

#### Байгаль орчны нөлөөлөл

Цаас үйлдвэрлэхэд ой мод багасгаж байгаа төдийгүй уур амьсгалын өөрчлөлт зэрэг байгаль орчны нөхцөл байдлыг улам дордуулж байна. Уур амьсгалын өөрчлөлт нь олон хүчин зүйлээс шалтгаалдаг. Ой модыг устгах нь агаар мандалд хүлэмжийн хий ихсэх гол шалтгаануудын нэг юм.

#### Эко шошго

Олон улсад хэрэглэгддэг болон дотоодод хэрэглэгдэх ногоон бүтээгдэхүүний гэрчилгээ, эко шошготой, чанар стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнийг худалдан авах нь ногоон худалдан авалтад тооцогдоно.

#### Ногоон шалгуур үзүүлэлт

##### Үндсэн шалгуур

- Таримал modoор үйлдвэрлэсэн;

- Хайрцаг, сав баглаа боодол нь 100 хувь дахин боловсруулсан, хадгалах, тээвэрлэхэд бат бөх байх.

### **Нэмэлт шалгуур**

- Хлоргүй байх /хлорын оронд устэрөгчийн хэт исэл ашиглан цайруулдаг. Энэ нь байгаль орчинд ээлтэй цайруулах арга бөгөөд TCF гэж тэмдэглэдэг/;
- 100 хувь дахин боловсруулсан түүхий эдээр боловсруулсан.

### Ногоон шалгуур үзүүлэлтийг баталгаажуулах

Бүтээгдэхүүн нийлүүлэгч нь ногоон шалгуур үзүүлэлтүүдийг хангаж буйг нотлох баримт бүрдүүлэх, түүхий эдийн гарал үүсэл, дахин боловсруулсан материал ашигласан эсэх, үйлдвэрлэгчийн техникийн тодорхойлолт эсхүл шалгуурыг хангаж байгааг харуулсан туршилтын тайлан зэргээр ногоон шалгуурыг хангаж байгаа эсэхийг тодорхойлно.

№	Шалгуур үзүүлэлт	Баталгаажуулалт
Үндсэн шалгуур		
1	Таримал modoор үйлдвэрлэсэн	Эко тэмдэг, тэмдэглэгээгээр
2	100 хувь дахин боловсруулсан түүхий эдээр боловсруулсан, дахин боловсруулах боломжтой	баталгаажсан байх, үйлдвэрлэгчийн техникийн тодорхойлолт
3	Хайрцаг, сав баглаа боодол нь 100 хувь дахин боловсруулсан, хадгалах, тээвэрлэхэд бат бөх байх	Эко тэмдэг, тэмдэглэгээгээр баталгаажсан байх, үйлдвэрлэгчийн техникийн тодорхойлолт
Үндсэн шалгуур		
4	Хлоргүй байх /хлорын оронд устэрөгчийн хэт исэл ашиглан цайруулдаг. Энэ нь байгаль орчинд ээлтэй цайруулах арга бөгөөд TCF гэж тэмдэглэдэг/	Үйлдвэрлэгчийн тодорхойлол эсхүл зөвшөөрөгдсөн байгууллагын туршилт, шинжилгээний тайлан
5	100 хувь дахин боловсруулсан түүхий эдээр боловсруулсан.	Үйлдвэрлэгчийн тодорхойлол эсхүл зөвшөөрөгдсөн байгууллагын туршилт, шинжилгээний тайлан

### Техникийн шалгуур үзүүлэлт болон стандарт

Захиалагч худалдан авах барааны техникийн шалгуур үзүүлэлт буюу бүтээгдэхүүний хэлбэр, хэмжээ, төрөл, жин зэрэг бараа бүтээгдэхүүнд шаардлагатай техникийн шалгуур үзүүлэлт болон стандартын шаардлагыг нэмэлтээр тусгаж болно.

### **3. Ажлын хувцас**

#### Хамрах хүрээ

**Захиалагчид шаардлагатай төрөл бүрийн нэхмэл материалыар хийгдэх дүрэмт хувцас, ажлын хувцас, дагалдах хэрэгслийг худалдан авахад тавигдах ногоон шалгуур үзүүлэлтийг тодорхойлох.**

### **Байгаль орчны нөлөөлөл**

Хөвөн, байгалийн утас тариалахтай холбоотой экосистемийн доголдол, нэхмэлийн үйлдвэрлэлд хэрэглэгддэг аюултай, хортой бодсын ялгаруулалт, байгалийн нөөцийн хэрэглээ (эрчим хүч, ус, түүхий эд), хувцас болон түүний баглаа боодол нь хог хаягдлыг бий болгох эх үүсвэр болох боломжтой юм.

### **Эко шошго**

Олон улсад хэрэглэгддэг болон дотоодод хэрэглэгдэх ногоон бүтээгдэхүүний гэрчилгээ, эко шошготой, чанар стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнийг худалдан авах нь ногоон худалдан авалтад тооцогдоно.

### **Ногоон шалгуур үзүүлэлт**

#### **Үндсэн шалгуур**

- Бүтээгдэхүүнд агуулагдах чөлөөт ба хэсэгчлэн гидролизжих формальдегидийн хэмжээ нь арьсанд шууд хүрдэг бүтээгдэхүүнд 80 ppm, бусад бүх бүтээгдэхүүнд 300 ppm-ээс ихгүй байх
- Дахин боловсруулах материалыар савласан байх

#### **Нэмэлт шалгуур**

- Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн явцад ус, эрчим хүчний үр ашиг өндөр байх;
- Бүтээгдэхүүн нь дахин боловсруулсан нэхмэл материал агуулсан байх;

### **Ногоон шалгуур үзүүлэлтийг баталгаажуулах**

Бүтээгдэхүүн нийлүүлэгч нь ногоон шалгуур үзүүлэлтүүдийг хангаж буйг нотлох баримт бүрдүүлэх шаардлагатай. Тухайлбал: аюултай бодис агуулаагүй, үйлдвэрлэгчийн техникийн тодорхойлолт эсхүл нийцэж буйг харуулсан хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагын туршилтын тайлан зэргээр ногоон шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхийг тодорхойлно.

№	Шалгуур үзүүлэлт	Баталгаажуулалт	
		Үндсэн шалгуур	
1	Бүтээгдэхүүнд агуулагдах чөлөөт ба хэсэгчлэн гидролизжих формальдегидийн хэмжээ нь арьсанд шууд хүрдэг бүтээгдэхүүнд 80 ppm, бусад бүх бүтээгдэхүүнд 300 ppm-ээс ихгүй байх	Үйлдвэрлэгчийн тодорхойлолт, байгууллагын тайлангаар тодорхойлох	Техникийн зөвшөөрөгдсөн шинжилгээний

2	Дахин боловсруулах материалаар	Тэмдэг, тэмдэглэгээтэй байх савласан байх
Нэмэлт шалгуур		
3	Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн явцад ус, эрчим явлад ус, эрчим хүчний үр ашигхүчний үр ашгийг тодорхойлсон өндөр байх	Үйлдвэрлэлийн явцад ус, эрчим хүчний үр ашигхүчний үр ашгийг тодорхойлсон үйлдвэрлэгчийн тодорхойлолт
4	Бүтээгдэхүүн нь дахин боловсруулсан нэхмэл боловсруулсан нэхмэл материал	Дахин боловсруулсан нэхмэл материалыг нотлох үйлдвэрлэгчийн тодорхойлолт

#### Техникийн шалгуур үзүүлэлт болон стандарт

Захиалагч худалдан авах барааны техникийн шалгуур үзүүлэлт буюу бүтээгдэхүүний хэлбэр, хэмжээ, төрөл, жин зэрэг бараа бүтээгдэхүүнд шаардлагатай техникийн шалгуур үзүүлэлт болон стандартын шаардлагыг нэмэлтээр тусгаж болно.

#### 4. Саван

##### Хамрах хүрээ

Захиалагчид шаардлагатай угаалгын өрөөний зориулалттай төрөл бүрийн гарын шингэн саван болон цэвэрлэгээний зориулалттай шингэн саван худалдан авахад тавигдах ногоон шалгуур үзүүлэлтийг тодорхойлох.

##### Байгаль орчны нөлөөлөл

Савангийн хэрэглээтэй холбоотой усанд ялгараах хорт бодис, химиин бодисын эрүүл мэндэд үзүүлэх нөлөө, сав баглаа боодлын хог хаягдал үүсэх, үйлдвэрлэлийн явцад эрчим хүчний хэрэглээ байгалийн нөөцийн хомсдол зэргээр байгаль орчинд нөлөөлж болох юм.

##### Эко шошго

Олон улсад хэрэглэгддэг болон дотоодод хэрэглэгдэх ногоон бүтээгдэхүүний гэрчилгээ, эко шошготой, чанар стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнийг худалдан авах нь ногоон худалдан авалтад тооцогдоно.

##### Ногоон шалгуур үзүүлэлт

##### Үндсэн шалгуур

- Бүтээгдэхүүн химиин хортой элемент буюу этилен-диамин-тетра-ацетат (EDTA) болон алкил фенол этоксилат (APEO) агуулаагүй байх;
- Дахин боловсруулах боломжтой сав баглаа боодлой байх;

##### Нэмэлт шалгуур

- Бүтээгдэхүүнийг ашиглах, устгах зааварчилгаатай байх;

#### Ногоон шалгуур үзүүлэлтийг баталгаажуулах

Бүтээгдэхүүн нийлүүлэгч нь ногоон шалгуур үзүүлэлтүүдийг хангаж буйг нотлох баримт бүрдүүлэх шаардлагатай. Тухайлбал: аюултай бодис агуулаагүй, үйлдвэрлэгчийн техникийн тодорхойлолт эсхүл нийцэж буйг харуулсан хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагын туршилтын тайлан зэргээр ногоон шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхийг тодорхойлно.

№	Шалгуур	Баталгаажуулалт
Үндсэн шалгуур		
1	Бүтээгдэхүүн химийн хортой элемент буюу этилен-диамин-тетра-ацетат (EDTA) болон алкилфенол этоксилат (APEO)/саванд агуулагддаг химийн хортой бодис бөгөөд эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй бодисууд юм/ агуулаагүй байх	Үйлдвэрлэгчийн тодорхойлолт, зөвшөөрөлдсөн байгууллагын шинжилгээний тайлан
2	Дахин боловсруулах боломжтой сав баглаа боодолтой байх	Үйлдвэрлэгчийн тодорхойлолт
Нэмэлт шалгуур		
3	Бүтээгдэхүүнийг ашиглах, устгах зааварчилгаатай байх	Үйлдвэрлэгчээс гаргасан зааварчилгаа

#### Техникийн шалгуур үзүүлэлт болон стандарт

Захиалагч худалдан авах барааны техникийн шалгуур үзүүлэлт буюу бүтээгдэхүүний хэлбэр, хэмжээ, төрөл, жин зэрэг бараа бүтээгдэхүүнд шаардлагатай техникийн шалгуур үзүүлэлт болон стандартын шаардлагыг нэмэлтээр тусгаж болно.

#### **5. Ажлын гутал**

##### Хамрах хүрээ

Захиалагчид шаардлагатай ажлын гутлыг худалдан авахад тавигдах ногоон шалгуур үзүүлэлтийг тодорхойлох.

##### Байгаль орчны нөлөөлөл

Хог хаягдал үүсгэх, үйлдвэрлэлийн явцад хүлэмжийн хийн ялгаруулалт, байгалийн нөөцийн хэрэглээ, эрүүл мэндийн сөргөөр нөлөөлөл байдлаар нөлөөлөл учирч болно.

## Эко шошго

Олон улсад хэрэглэгддэг болон дотоодод хэрэглэгдэх ногоон бүтээгдэхүүний гэрчилгээ, эко шошготой, чанар стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнийг худалдан авах нь ногоон худалдан авалтад тооцогдоно.

### Ногоон шалгуур үзүүлэлт

#### Үндсэн шалгуур

- Бүтээгдэхүүний материалын тодорхой хувь нь дахин боловсруулсан байх
- Хүнд металл агуулаагүй байх

#### Нэмэлт шалгуур

- Эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй

### Ногоон шалгуур үзүүлэлтийг баталгаажуулах

Бүтээгдэхүүн нийлүүлэгч нь ногоон шалгуур үзүүлэлтүүдийг хангаж буйг нотлох баримт бүрдүүлэх шаардлагатай. Тухайлбал: хортой бодис агуулаагүй, үйлдвэрлэгчийн техникийн тодорхойлолт эсхүл нийцэж буйг харуулсан хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагын туршилтын тайлан зэргээр ногоон шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхийг тодорхойлно.

№	Шалгуур үзүүлэлт	Баталгаажуулалт
Үндсэн шалгуур		
1	Бүтээгдэхүүний материалын тодорхой хувь нь дахин боловсруулсан байх	Үйлдвэрлэгчийн зөвшөөрөгдсөн тодорхойлолт, байгууллагын шинжилгээний тайлан
2	Хүнд металл агуулаагүй байх	Үйлдвэрлэгчийн зөвшөөрөгдсөн тодорхойлолт, байгууллагын шинжилгээний тайлан
Нэмэлт шалгуур		
3	Эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байх	Үйлдвэрлэгчийн болон байгууллагын тодорхойлолт зөвшөөрөгдсөн шинжилгээний тайлан

### Техникийн шалгуур үзүүлэлт болон стандарт

Захиалагч худалдан авах барааны техникийн шалгуур үзүүлэлт буюу бүтээгдэхүүний хэлбэр, хэмжээ, төрөл, жин зэрэг бараа бүтээгдэхүүнд шаардлагатай техникийн шалгуур үзүүлэлт болон стандартын шаардлагыг нэмэлтээр тусгаж болно.

## 6. Ширээ

### Хамрах хүрээ

Захиалагч шаардлагатай мод, модны үртсээр хийдэг шахмал ширээ худалдан авахад тавигдах ногоон шалгуур үзүүлэлтийг тодорхойлох.

### Байгаль орчны нөлөөлөл

Эрүүл мэндийн сөрөг нөлөө, байгаль орчны нөөцийн хэрэглээ /мод, ус, эрчим хүч/, түүхий эдийг үйлдвэрлэлийн явцад хүлэмжийн хийн ялгаруулалт үйлдвэрлэлийн эрчим хүчний хэрэглээ нь байгаль орчинд нөлөөлж байна.

### Ногоон шалгуур үзүүлэлт

#### Үндсэн шалгуур

- Олон улсад Е0, Е1 стандартын тавилга хийх зориулалттай түүхий эдээр хийгдсэн байх;

тайлбар: Е0 стандартын хавтангаар хийсэн тавилгад формалдегидийн агууламж 100 гр-д 0.5 мг/л хэмжээнээс бага, байгаль орчинд ээлтэй, эко тавилга гэж тооцогддог.

Е1 стандартын хавтан нь формалдегидийн агууламж 1.5 мг/л хэмжээнээс бага, европын стандарт бөгөөд хүний биед хор нөлөө үзүүлэхгүй, формальдегидийн хэмжээ нь зөвшөөрөгдсөн хэмжээнд байдаг. Харин Е2 ≤ 5.0 мг/л хавтанг гадуур нь бүрсэн тохиолдолд тавилгад хэрэглэж болох эко гэж үздэг.

- Дахин боловсруулсан бүтээгдэхүүнээр хийсэн сав баглаа боодолтой байх;
- Таримал modoор үйлдвэрлэсэн байх.

#### Нэмэлт шалгуур

- Дахин боловсруулсан түүхий эдээр хийгдсэн байх;
- Хүний биед сөрөг нөлөөгүй байх.

### Ногоон шалгуур үзүүлэлтийг баталгаажуулах

Бүтээгдэхүүн нийлүүлэгч нь ногоон шалгуур үзүүлэлтүүдийг хангаж буйг нотлох баримт бүрдүүлэх шаардлагатай. Тухайлбал Е0, Е1 стандартын гэрчилгээ авсан, хэрэв Бүгд Найрамдах Хятад Ард Улсад үйлдвэрлэгдсэн бол Е0 гэсэн гэрчилгээ болон зориулалтын таних тэмдэглэлтэй бараа бүтээгдэхүүнийг ногоон шалгуур үзүүлэлтийн шаардлага хангаж байгаа эсэхийг тодорхойлно.

№	Шалгуур үзүүлэлт	Баталгаажуулалт
		Үндсэн шалгуур

1	Олон улсад Е0, Е1 стандартын тавилга хийх зориулалттай түүхий эдээр хийгдсэн байх	Үйлдвэрлэгчийн болон зөвшөөрөгдсөн байгууллагын шинжилгээний тайлан
2	Дахин боловсруулсан бүтээгдэхүүнээр хийсэн сав баглаа боодолтой байх	Үйлдвэрлэгчийн тодорхойлолт болон эко шошго, тэмдэг, тэмдэглэгээтэй байх
3	Таримал modoор үйлдвэрлэсэн байх	Үйлдвэрлэгчийн тодорхойлолт болон эко шошго, тэмдэг, тэмдэглэгээтэй байх
Нэмэлт шалгуур		
4	Дахин боловсруулсан түүхий эдээр хийгдсэн байх	Үйлдвэрлэгчийн тодорхойлолт техникийн
	Хүний биед сөргө нөлөөгүй байх	Үйлдвэрлэгчийн тодорхойлолт болон зөвшөөрөгдсөн байгууллагын шинжилгээний тайлан

### Эко шошго

Олон улсад хэрэглэгддэг болон дотоодод хэрэглэгдэх ногоон бүтээгдэхүүний гэрчилгээ, эко шошготой, чанар стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнийг худалдан авах нь ногоон худалдан авалтад тооцогдоно.

### Техникийн шалгуур үзүүлэлт болон стандарт

Захиалагч худалдан авах барааны техникийн шалгуур үзүүлэлт буюу бүтээгдэхүүний хэлбэр, хэмжээ, төрөл, жин зэрэг бараа бүтээгдэхүүнд шаардлагатай техникийн шалгуур үзүүлэлт болон стандартын шаардлагыг нэмэлтээр тусгаж болно.

### **7. Сандал**

#### Хамрах хүрээ

Захиалагчид шаардлагатай хуванцар материалыар хийгдсэн сандал худалдан авахад тавигдах ногоон шалгуур үзүүлэлтийг тодорхойлох.

#### Байгаль орчны нөлөөлөл

Үйлдвэрлэлийн үе шатанд хүлэмжийн хийн ялгаруулалтын хэмжээ, ашигласан хуванцар материалын нөөцийн хэрэглээ, сав баглаа боодол хог хаягдал үүсгэх байдлаар нөлөөлж байна.

### Эко шошго

Олон улсад хэрэглэгддэг болон дотоодод хэрэглэгдэх ногоон бүтээгдэхүүний гэрчилгээ, эко шошготой, чанар стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнийг худалдан авах нь ногоон худалдан авалтад тооцогдоно.

## Ногоон шалгуур үзүүлэлт

### Үндсэн шалгуур

- Нийлүүлэгч нь хар тугалга, хром, кадми, мөнгөн ус, фталат, галогенжуулсан органик бодис агуулаагүй хуванцар материалыаар хийгдсэн байх;
- Дахин боловсруулах боломжтой бусад материалын хольцгүй байх;
- Сав баглаа боодлыг дахин боловсруулсан байх.

### Нэмэлт шалгуур

- Эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байх

## Ногоон шалгуур үзүүлэлтийг баталгаажуулах

Бараа бүтээгдэхүүн нь ногоон шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа талаарх нотлох баримтыг ирүүлэх шаардлагатай. Мөн үйлдвэрлэгчийн техникийн тодорхойлолт эсхүл холбогдох шалгуурыг хангаж байгааг тодорхойлсон туршилтын тайлан зэргийг харгалзан шалгуурыг хангаж байгаа эсэхийг тодорхойлох боломжтой юм.

№	Шалгуур үзүүлэлт	Баталгаажуулалт	
		Үндсэн шалгуур	
1	Нийлүүлэгч нь хар тугалга, хром, кадми, мөнгөн ус, фталат, галогенжуулсан органик бодис агуулаагүй хуванцартайлан материалыаар хийгдсэн байх	Үйлдвэрлэгчийн болон байгууллагын хуванцартайлан	тодорхойлолт зөвшөөрөгдсөн шинжилгээний
2	Дахин боловсруулах боломжтой бусад материалын хольцгүй байх		
3	Сав баглаа боодлыг дахин боловсруулсан байх	Үйлдвэрлэгчийн болон эко шошго, тэмдэг, тэмдэглэгээтэй байх	тодорхойлолт зөвшөөрөгдсөн шинжилгээний
Нэмэлт шалгуур			
4	Эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байх	Үйлдвэрлэгчийн болон байгууллагын тайлан	тодорхойлолт зөвшөөрөгдсөн шинжилгээний

## Техникийн шалгуур үзүүлэлт болон стандарт

Захиалагч худалдан авах барааны техникийн шалгуур үзүүлэлт буюу бүтээгдэхүүний хэлбэр, хэмжээ, төрөл, жин зэрэг бараа бүтээгдэхүүнд шаардлагатай техникийн шалгуур үзүүлэлт болон стандартын шаардлагыг нэмэлтээр тусгаж болно.

## **8. Компьютер/дэлгэц**

### Хамрах хүрээ

Захиалагчид шаардлагатай ширээний болон зөөврийн компьютер, дэлгэц худалдан авахад тавигдах ногоон шалгуур үзүүлэлтийг тодорхойлох.

### Байгаль орчны нөлөөлөл

Ашиглалтын үеийн эрчим хүчиний хэрэглээ, байгалийн нөөцийн хэрэглээ /газрын ховор элемент, металл, хуванцар/, түүхий эд олборлох, эд анги үйлдвэрлэлтэй холбоотой хүлэмжийн хий ялгаруулалт, металл болон хуванцар хог хаягдал үүсгэх байдлаар нөлөөлж байна.

### Эко шошго

Олон улсад хэрэглэгддэг болон дотоодод хэрэглэгдэх ногоон бүтээгдэхүүний гэрчилгээ, эко шошготой, чанар стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнийг худалдан авах нь ногоон худалдан авалтад тооцогдоно.

### Ногоон шалгуур үзүүлэлт

#### Үндсэн шалгуур

- Ашиглалтын явцад эрчим хүчиний хэмнэлттэй /дотоодын стандартын дагуу хамгийн багадаа “үр ашигтай” байх/;
- Сав баглаа боодлыг дахин боловсруулсан байх;
- Бүтээгдэхүүний дотоод эд анги, нийтлэг, сольж сайжруулахад хялбар боломжтой байх.

#### Нэмэлт шалгуур

- Дахин боловсруулах боломжтой, ашиглалтын хугацаа удаан байх

### Ногоон шалгуур үзүүлэлтийг баталгаажуулах

Эрчим хүчиний хэрэглээний түвшнийг нотлох үйлдвэрлэгчийн техникийн тодорхойлолт эсхүл хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагын туршилтын тайлан шаардлагыг хангаж байгааг нотлох шаардлагатай.

Үйлдвэрлэгчийн баталгаат хугацааг тодорхойлох болон сэлбэг хэрэгслийн бэлэн байдлын баталгааг илэрхийлэх баримт нь ашиглалтын хугацааг тодорхойлох боломжтой юм. Мөн сав баглаа боодол буцаан авах үйлчилгээ үзүүлэхдээ нийцэж байгаа эсэхээ компанийн гүйцэтгэх захидал эсхүл хамтран ажиллагчийн гарын үсэг бүхий бичиг зэргийг хавсаргах юм.

№	Шалгуур үзүүлэлт	Баталгаажуулалт
	Үндсэн шалгуур	

1	Ашиглалтын явцад эрчим хүчний хэмнэлттэй стандартын дагуу хамгийн багадаа "үр ашигтай" хэрэглээтэй байх/	Үйлдвэрлэгчийн тодорхойлолт, эко /дотоодын шошго, тэмдэг, тэмдэглэгээтэй байх
2	Бүтээгдэхүүний дотоод эд анги, нийтлэг, сольж сайжруулахад хялбар боломжтой байх	Үйлдвэрлэгчийн тодорхойлолт
3	Сав баглаа боодлыг дахин боловсруулсан байх	Үйлдвэрлэгчийн тодорхойлолт, эко шошго, тэмдэг, тэмдэглэгээтэй байх
Нэмэлт шалгуур		
4	Дахин боловсруулах боломжтой, ашиглалтын хугацаа удаан байх	Зөвшөөрөгдсөн байгууллагын туршилтын тайлан

#### Техникийн шалгуур үзүүлэлт болон стандарт

Захиалагч худалдан авах барааны техникийн шалгуур үзүүлэлт буюу бүтээгдэхүүний хэлбэр, хэмжээ, төрөл, жин зэрэг бараа бүтээгдэхүүнд шаардлагатай техникийн шалгуур үзүүлэлт болон стандартын шаардлагыг нэмэлтээр тусгаж болно.

#### 9. Принтер/Хувилагч/

##### Хамрах хүрээ

Захиалагч шаардлагатай бүх төрлийн цаас хувилагч болон бүх төрлийн принтер худалдан авахад тавигдах ногоон шалгуур үзүүлэлтийг тодорхойлох.

##### Байгаль орчны нөлөөлөл

Ашиглалтын үеийн эрчим хүчний хэрэглээ, байгалийн нөөцийн хэрэглээ /газрын ховор элемент, металл, хуванцар/, түүхий эд олборлох, эд анги үйлдвэрлэлтэй холбоотой хүлэмжийн хий ялгаруулалт, металл болон хуванцар хог хаягдал үүсгэх байдлаар нөлөөлж байна.

##### Эко шошго

Олон улсад хэрэглэгддэг болон дотоодод хэрэглэгдэх ногоон бүтээгдэхүүний гэрчилгээ, эко шошготой, чанар стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнийг худалдан авах нь ногоон худалдан авалтад тооцогдоно.

##### Ногоон шалгуур үзүүлэлт

##### Үндсэн шалгуур

- Ашиглалтын явцад эрчим хүчний хэмнэлттэй /дотоодын стандартын дагуу хамгийн багадаа "үр ашигтай" байх/;

- Сав баглаа боодлыг дахин боловсруулсан байх;
- Бүтээгдэхүүний дотоод эд анги, нийтлэг, сольж сайжруулахад хялбар боломжтой байх.

#### Нэмэлт шалгуур

- Дахин боловсруулах боломжтой, ашиглалтын хугацаа удаан байх

#### Ногоон шалгуур үзүүлэлтийг баталгаажуулах

Эрчим хүчний хэрэглээний түвшнийг нотлох үйлдвэрлэгчийн техникийн тодорхойлолт эсхүл хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагын туршилтын тайлан шаардлагыг хангаж байгааг нотлох шаардлагатай.

№	Шалгуур үзүүлэлт	Баталгаажуулалт		
			Үндсэн шалгуур	
1	Ашиглалтын явцад эрчим хүчний хэмнэлттэй /дотоодын стандартын дагуу хамгийн багадаа “ур ашигтай” хэрэглээтэй байх/	Үйлдвэрлэгчийн тодорхойлолт, эко шошго, тэмдэг, тэмдэглэгээтэй байх		
2	Бүтээгдэхүүний дотоод эд анги, нийтлэг, сольж сайжруулахад хялбар боломжтой байх	Үйлдвэрлэгчийн тодорхойлолт		
3	Сав баглаа боодлыг дахин боловсруулсан байх	Үйлдвэрлэгчийн тодорхойлолт, эко шошго, тэмдэг, тэмдэглэгээтэй байх		
Нэмэлт шалгуур				
4	Дахин боловсруулах боломжтой, ашиглалтын хугацаа удаан байх	Зөвшөөрөгдсөн ашиглалтын хугацаа удаан байх	байгууллагын туршилтын тайлан	

#### Техникийн шалгуур үзүүлэлт болон стандарт

Захиалагч худалдан авах барааны техникийн шалгуур үзүүлэлт буюу бүтээгдэхүүний хэлбэр, хэмжээ, төрөл, жин зэрэг бараа бүтээгдэхүүнд шаардлагатай техникийн шалгуур үзүүлэлт болон стандартын шаардлагыг нэмэлтээр тусгаж болно.

#### **10. Скайнер**

##### Хамрах хүрээ

Захиалагчид шаардлагатай бүх төрлийн скайнер худалдан авахад тавигдах ногоон шалгуур үзүүлэлтийг тодорхойлох.

##### Байгаль орчны нөлөөлөл

Ашиглалтын үеийн эрчим хүчний хэрэглээ, байгалийн нөөцийн хэрэглээ /газрын ховор элемент, металл, хуванцар/, түүхий эд олборлох, эд анги үйлдвэрлэлтэй холбоотой хүлэмжийн хий ялгаруулалт, металл болон хуванцар хог хаягдал үүсгэх байдлаар нөлөөлж байна.

### Эко шошго

Олон улсад хэрэглэгддэг болон дотоодод хэрэглэгдэх ногоон бүтээгдэхүүний гэрчилгээ, эко шошготой, чанар стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнийг худалдан авах нь ногоон худалдан авалтад тооцогдоно.

### Ногоон шалгуур үзүүлэлт

#### Үндсэн шалгуур

- Ашиглалтын явцад эрчим хүчний хэмнэлттэй /дотоодын стандартын дагуу хамгийн багадаа “үр ашигтай” байх/;
- Дахин боловсруулах боломжтой, ашиглалтын хугацаа удаан, дахин ашиглах боломжтой байх;
- Сав баглаа боодлыг дахин боловсруулсан байх;
- Бүтээгдэхүүний дотоод эд анги, нийтлэг, сольж сайжруулахад хялбар боломжтой байх.

#### Нэмэлт шалгуур

- Дахин боловсруулах боломжтой, ашиглалтын хугацаа удаан байх

### Ногоон шалгуур үзүүлэлтийг баталгаажуулах

Эрчим хүчний хэрэглээний түвшнийг нотлох үйлдвэрлэгчийн техникийн тодорхойлолт эсхүл хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагын туршилтын тайлан шаардлагыг хангаж байгааг нотлох шаардлагатай.

№	Шалгуур үзүүлэлт	Баталгаажуулалт	
		Үндсэн шалгуур	
1	Ашиглалтын явцад эрчим хүчний хэмнэлттэй /дотоодын стандартын дагуу хамгийн багадаа “үр ашигтай” хэрэглээтэй байх/	Үйлдвэрлэгчийн тодорхойлолт, эко шошго, тэмдэг, тэмдэглэгээтэй байх	
2	Бүтээгдэхүүний дотоод эд анги, нийтлэг, сольж сайжруулахад хялбар боломжтой байх	Үйлдвэрлэгчийн тодорхойлолт	
3	Сав баглаа боодлыг дахин боловсруулсан байх	Үйлдвэрлэгчийн тодорхойлолт, эко шошго, тэмдэг, тэмдэглэгээтэй байх	
Нэмэлт шалгуур		Зөвшөөрөгдсөн байгууллагын туршилтын тайлан	
4	Дахин боловсруулах боломжтой, ашиглалтын хугацаа удаан байх	Зөвшөөрөгдсөн байгууллагын туршилтын тайлан	

## Техникийн шалгуур үзүүлэлт

Захиалагч худалдан авах барааны техникийн шалгуур үзүүлэлт буюу бүтээгдэхүүний хэлбэр, хэмжээ, төрөл, жин зэрэг бараа бүтээгдэхүүнд шаардлагатай техникийн шалгуур үзүүлэлт болон стандартын шаардлагыг нэмэлтээр тусгаж болно.

### **11. Хөнгөн бетон блок**

#### Хамрах хүрээ

Захиалагчид шаардлагатай хөнгөн бетон блок худалдан авахад тавигдах ногоон шалгуур үзүүлэлтийг тодорхойлох.

#### Байгаль орчны нөлөөлөл

Ашиглалтын үеийн эрчим хүч, усны хэрэглээ, байгалийн нөөцийн хэрэглээ, хог хаягдал үүсгэх байдлаар нөлөөлж байна.

#### Эко шошго

Олон улсад хэрэглэгддэг болон дотоодод хэрэглэгдэх ногоон бүтээгдэхүүний гэрчилгээ, эко шошготой, чанар стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнийг худалдан авах нь ногоон худалдан авалтад тооцогдоно.

#### Ногоон шалгуур үзүүлэлт

##### Үндсэн шалгуур

- Үйлдвэрлэлийн үеийн эрчим хүчиний хэмнэлттэй байх;
- Усны хэмнэлттэй байх.

##### Нэмэлт шалгуур

- Ашиглагдах түүхий эдийн эко байдал;
- Дахин боловсруулсан /түүхий эд/.

#### Ногоон шалгуур үзүүлэлтийг баталгаажуулах

Эрчим хүчиний хэрэглээний түвшнийг нотлох үйлдвэрлэгчийн техникийн тодорхойлолт эсхүл хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагын туршилтын тайлан шаардлагыг хангаж байгааг нотлох шаардлагатай.

№	Шалгуур үзүүлэлт	Баталгаажуулалт
Үндсэн шалгуур		
1	Үйлдвэрлэлийн үеийн эрчим хүчиний хэмнэлттэй байх	Үйлдвэрлэлийн явцад эрчим хүчиний хэмнэлтийг тодорхойлсон шинжилгээний тайлан үйлдвэрлэгчийн тодорхойлолт

2	Усны хэмнэлттэй байх	үйлдвэрлэлийн явцад усны хэмнэлтийг тодорхойлсон шинжилгээний тайлан үйлдвэрлэгчийн тодорхойлолт Нэмэлт шалгуур
3	Ашиглагдах түүхий эдийн экотүүхий эд материалын орц байдал байх	найрлага нь стандартын шаардлага хангасан талаарх нотлох баримт ирүүлэх
4	Дахин боловсруулсан /түүхий эд/	Үйлдвэрлэгчийн тодорхойлолт

#### Техникийн шалгуур үзүүлэлт болон стандарт

Захиалагч худалдан авах барааны техникийн шалгуур үзүүлэлт буюу бүтээгдэхүүний хэлбэр, хэмжээ, төрөл, жин зэрэг бараа бүтээгдэхүүнд шаардлагатай техникийн шалгуур үзүүлэлт болон стандартын шаардлагыг нэмэлтээр тусгаж болно.